



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 443,685,696.00 (дөрвөн зуун дөчин гурван сая зургаан зуун наян таван мянга зургаан зуун ерэн зургаан төгрөг) төгрөгийн балансын үнэ, 421,045,708.00 (дөрвөн зуун хорин нэгэн сая дөчин таван мянга долоон зуун найман төгрөг) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгийг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэн, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал Х.Бадамсүрэн, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Ч.Эрдэнэбаатар, “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Нямтуул, “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үйлдвэрийн газрын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

З.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

0000011



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 02 дугаар сарын 17 ны өдрийн
142 дугаар тогтоолын хавсралт

"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Шилжүүлэх байгууллагын нэр
1	Тоёота Ландкрүйзер 200, 25-25 ОРХ, арлын дугаар JTMHV09J3C4075353	2012/2014	133,176,400.00	110,536,412.00	22,639,988.00	Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар
2	Тоёота Ландкрүйзер 200, 99-26 УБҮ, арлын дугаар JTMHX05J404022091	2012/2012	150,000,000.00	150,000,000.00	-	"Баруун бүсийн эрчим хүчний систем" ТӨХК
3	Тоёота Ландкрүйзер Прадо 150, 72-88 УНҮ, арлын дугаар JTEBX9FJ4DK113092	2012/2013	101,434,135.00	101,434,135.00	-	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
4	Ниссан Патфиндер, 09-77 УБЗ, арлын дугаар VSKJLWRS1Z0208147	2007/2007	59,075,161.00	59,075,161.00	-	"Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК
			443,685,696.00	421,045,708.00	22,639,988.00	
Балансаас балансад шилжүүлэх тээврийн хэрэгслийн нийт дүн			дөрвөн зуун дөчин гурван сая зургаан зуун наян таван мянга зургаан зуун ерэн зургаан төгрөг	дөрвөн зуун хорин нэгэн сая дөчин таван мянга долоон зуун найман төгрөг	хорин хоёр сая зургаан зуун гучин есөн мянга есөн зуун наян найман төгрөг	-